

БИДИСЕК ҮЦК ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 2 сарын 19-ний өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

Компанийн тухай хуулийн 46.5-р зүйл, “Далайван аудит” ХХК-ийн баталгаажуулсан 2017 оны Санхүүгийн тайлан болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн олонхийн саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани санхүүгийн байдалтай холбогдуулан 2017 оны үр дүнгээр хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хувиарлахгүй байхаар тогтоосугай.
2. Энэхүү тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Д.ДАЯНБИЛГҮҮН/-д үүрэг болгосугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:**



/Б.ЛХАГВАДОРЖ/

БИДИСЕК ҮЦК ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 3 сарын 13-ны өдөр

№ 1

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

“БиДиСек ҮЦК” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай асуудлаар санал хурааж, олонхийн саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “БиДиСек ҮЦК” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2018 оны 4 сарын 23-ны өдөр 10 цагт Улаанбаатар хотод “БиДиСек ҮЦК” ХК-ийн өөрийн байранд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - a) Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан дүгнэлтийг тайлагнах
 - b) Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт
 - c) Компани ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ–н гаргасан шийдвэрийг танилцуулах
 - d) ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
 - e) ТУЗ-ийн 2018 оны төсөв батлах
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2018 оны 4 дугаар сарын 2-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2018 оны 3 дугаар сарын 16-ны өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компани хөрөнгийн биржийн цахим хуудсаар

мэдээлэх. Энэ мэдээллийг анх зар хүргэсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 3 дугаар сарын 31-ний өдөр дахин зар гаргахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг 01 дүгээр хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь энэхүү шийдвэрийн 02 дугаар хавсралтанд заасан бичиг баримттай 2018 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөс 2018 оны 4-р сарын 22-ны өдөр хүртэл 09⁰⁰-18⁰⁰ цагийн хооронд “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн байранд ирж танилцах эрхтэй болохыг дурьдсугай.
6. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг 03 дугаар хавсралтаар баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг харьяалагдах үнэт цаасны компаниар нь дамжуулан хурал хуралдах өдрөөс ажлын 1 хоногийн өмнө байхаар тогтсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар О.Уранбайгаль гишүүнээр Б.Тэмүүлэн нарыг тус тус томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Компанийн Тэргүүн Дэд захирал Б.Лхагвадорж, тооллогын комиссын даргаар “БиДиСек ҮЦК” ХК-ийн мэргэжилтэн Б.Долгормаа, гишүүдээр “БиДиСек ҮЦК” ХК-ийн мэргэжилтэн Д.Шүрэнцэцэг нарыг тус тус томилсугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:**



/Б.ЛХАГВАДОРЖ/

БИДИСЕК ҮЦК ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 3 сарын 13-ны өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан,

түүнд хийгдсэн хараат бус аудитын тайлангийн

талаарх ТУЗ-ийн дүгнэлтийн тухай

Компанийн тухай хуулийн 76.1.11 дэх заалт Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайлан болон аудитлагдсан санхүүгийн тайланг хангалттай гэж үзсүгэй.
2. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт, тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хэлэлцүүлэхийг ТУЗ – ийн дарга /Б.Лхагвадорж /-д даалгасгай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:**



/Б.ЛХАГВАДОРЖ/

БИДИСЕК ҮЦК ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 2 сарын 19-ний өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

ТУЗ-ын нарийн бичгийн даргыг томилох тухай

Монгол улсын компаний тухай хуулийн 82-р зүйлийн 82.1 дэх заалт, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхийн саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад Батсүх овогтой Тэмүүлэн /РД:У395012704/-г томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Б.ЛХАГВАДОРЖ/